

“ТАВАН АЙМГИЙН ҮЕ ЗАЛГАМЖ”-ИЙН ДОТОРХ
ПЕРС, МОНГОЛ ХОЁР ХЭЛЭЭР БИЧСЭН
АЛТАН УРГИЙН ҮЕ ЗАЛГАМЖИЙН ТУХАЙ

Цэнгэл¹

Агуулгын товч:

Тус өгүүлэлд Ил хаант улсын үед туурвисан “Таван аймгийн үе залгамж” хэмээх хаад ноёдын үе залгамжийн бичгийн судлагдсан байдал, түүн дотор буй перс, монгол хоёр хэлээр бичигдсэн алтан ургийн үе хэлхээний хэв хэлбэр, агуулгын тухай танилцуулжээ.

Түлхүүр үг:

Ил хаант улс, алтан ургийн үе залгамж, Рашид Ад Дин.

Ил хаант улсын үе (1260-1355) –д перс, монгол хоёр хэлээр бичсэн “Таван аймгийн үе залгамж” хэмээх монголын алтан ургийн үе хэлхээг багтаасан нэгэн нандин дурсгал бичиг судлаачдын анхааралд өртөөд нэлээд удаж байгаа хэдий ч, уг дурсгал бодитоор нийтлэгдээгүй учир монгол судлалд өргөнөөр ашиглагдах боломж дутагдсаар иржээ.

Иймд миний бие Турк улсын эрдэмтний дэмжлэгээр, уул дурсгал бичгийг шинээр, дижитал хэлбэрээр хэвлэн нийтлэх зөвшөөрөл аван ажиллаж буй бөгөөд энэ дашрамд энэ чухал дурсгалын судлагдсан байдал, хэлбэр агуулгын нь талаар товч танилцуулахыг хүслээ.

I. Судалсан байдал

Тус дурсгалт бичгийг 1927 онд Туркийн эрдэмтэн A.Zeki Velidi Togan (1890-1970) Турк улсын “*Topkapi Sarayi*” хэмээх музей (III. АНМЕТ. 2937,42 x 35,5)-гээс анх олжээ. Тэр цагаас хойш “*Shu’ab-i Panjgena*” хэмээх нэр (персээр)- зэр буюу “*Таван зүйлийн үе залгамж*”, “*Таван аймгийн үе залгамж*” нэрээр алдаршжээ. Бид эл судалгааны өгүүлэлдээ хоёр дахь нэдлыг нь сонгон хэрэглсэн болно.

1. БНХАУ, Нийгмийн Шинжлэх Ухааны Академи, Түүхийн Хүрээлэн

Цэнгэл

Тус дурсгалт бичгийн гадна болон дотор талд уг нэр байхгүй, харин хавтасны гадар талд гадар талд нь персээр “*kitab-i nasab-nama-yi mulūk*” гэж байх ба үүнийг монгол хэлээр орчуулбал “Хаадибал “Хаадын үе залгамжийн бичиг” гэсэн утгатай болох юм.

XX зууны 30-аад онд японы монгол судлаач Кобаяши Такаширо (1905-1987) уг дурсгалуг дурсгалын бүрэн биш эхийг фото зурагт буулгаж улсдаа авчирсан нь К.Такаширогийн “Дорно дахиорно дахины судалгааны номын гарчиг” (нэг), “Перс хэлний хуучин бичмэл номын фото зургийн гарчигийн гарчиг”² –т оржээ.

1962 онд A.Zeki Velidi Togan “Рашид Ад Диний туурвисан монгол түүхийн бүтээл”³ хэмэгээл³ хэмээх өгүүлэл бичиж, эх бичгийн хувьд анхны шинжлэл хийжээ.

1980-аад онд японы монгол судлаач Сигияма Масааки бүх эх бичгийг фото зургаар дахургаар дахин буулгаж авчирсан нь японы судлаачдын дунд ихээхэн дэлгэрчээ. Мөн тэрээр 1988 оны 11-р сард болсон Японы түүхийн ухааны эрдэм шинжилгээний ээлжит хурал дээр дэлгэрэнг дэлгэрэнгүй танилцуулсан байна.⁴

“Эрдэмтэн Шимо Хиротоши “Перс хэл соёлын тойрог үүсч хөгжсөн тухай ерөнхий судалгаа”-г судалгаа”-ны дугуйлан зохион байгуулж, түүнд агуулагдаж байгаа монгол хаадын үе залгамжийн доторх нон доторх ноёд түшмэд болон хатдын нэрсүүдийг сийрүүлэн буулгаж, 1988 онд нийтэлсэн нь энэ материалээ материалыг ашигласан бололтой.⁵

1980-аад оноос хойш Японд “Таван аймгийн үе залгамж”-ийг судлах, ашиглах талаар Шиталаар Шимо Хиротоши, Хонда Минубо, Акасака Цүнеаки, Мацуда Коичи, Мураока Хитоши ... зэрэг судлаачийн олон өгүүлэл, бүтээл хэвлэгдэн гарав.⁶

Хэрэв Хонда Минубо, Сигияма Масааки нар японы “Таван аймгийн үе залгамж” судлалыг судлалын үндсэн суурийг тавсан бол, залуу монголч эрдэмтэн Акасака Цүнеаки нарийн нямбай эх бичгийн шинжлэл хийж, тэр судалгааг урагш ахиулжээ. Эдүгээ тус дурсгалт бичиг нь японы эрдэмтэний эрдэмтэд Монгол хаант улс, Юань улс, Төв азийг судлахад дутагдаж болшгүй суурь хэрэглэгдэхүрэгдэхүүн болсон байна.

БНХАУ-д Июй да жун (“БНХАУ-ын нэвтэрхий толь”)-ы “Судрын чуулган”-ы хэсэгт “Архэсэгт “Араб, Еврей, Монгол, Франк, Хятад таван үндэстний үе залгамжийн бичиг” хэмээх нэгэн нэр дурдсан нэр дурдсан нь тус дурсгалыг заасан бололтой.⁷

2. 遠峯四郎:《小林学士将来東洋学書目録(一)-波斯文古抄本撮影目録》《東洋学報》32,1,1948. 1948.

3. A.Zeki Velidi Togan. *The Composition of the history of the Mongols by Rasho Al-Don*, *Central Asiatic Journal*, *voic Journal*, vol. VII, Nr. 1, 1962.3.

4. 杉山正明『五族譜簡介』1988年11月13日, 日本史学会。

5. 志茂碩敏『ペルシア語古写本史料精査によるモンゴル帝国の諸王家に関する総合的研究』1997. 1997.

6. 本田実信『チンギス・ハンの千戸—<元朝秘史>とラシード<集史>との比較を通じて—』『史学雑誌』『史学雑誌』第62巻第8号、1954.志茂碩敏『ペルシア語文化圏の成立と展開に関する総合的研究』1988.本田実信『モンゴ実信『モンゴル時代史研究』東京大学出版社,1991.杉山正明『八不沙大王の令旨碑より』『東洋史研究』52:3,1993.松2:3,1993.松田孝一『オゴデイ諸子ウルスの系譜と継承—ペルシア語写本史料精査によるモンゴル帝国の諸王家に関する王家に関する総合的研究』(研究代表者志茂碩敏)1996.村岡倫『オゴデイ=ウルスの分立』『東洋史苑』39,1992.杉山正明『モンゴル帝国と大元ウルス』京都大学学術出版会,2004.岩武昭男『ラシード著作全集の編纂—<ワッ編纂—<ワッサーフ史>著者自筆写本の記述より—』『東洋学報』第78巻第4号1994.赤坂恒明『ジュチ裔諸政権史の研究政権史の研究』東京,風間書房,2005.赤坂恒明『<五族口>と<史集>編纂』『史観』第130冊、1994.赤坂恒明『<五族口>『<五族口>モンゴル分支と<史集>の関係』『早稲田大学大学院文学研究科紀要』第41輯第4分冊、1994.赤坂恒明『<五族口>モンゴル分支と<史集>口写本』『アジア・アフリカ言語文化研究』1998,55.

7. 《中国百科全口・中国史・元史》中国大百科全口出版社、1985年。

Цэнгэл

Мөн Жан ЧМөн Жан Чан Ли, Ван И Дан нар А.Zeki Velidi Togan-ий судлалаас товч ашигласан төдий бий.⁸ бий.⁹

“Таван айм” “Таван аймгийн үе залгамж” нь түүх соёлын нандин чухал дурсгал бичиг мөн болохыг эрдэмтдийн эрдэмтдийн судалгаа харуулж буй. Харин зохиогч ба эх бичиг буй болсон цаг үеийн асуудлын талаар эрдэмтдээр эрдэмтдийн санал үзэлт багагүй зөрөөтэй байдаг. Тухайлбал А.Zeki Velidi Togan дээр дурдсан өгүүрдсэн өгүүлэлдээ Ил хаад улсын алдарт түүхч Рашид Ад Дин (Rashod al-Don, 1247-1318) туурвижээ гүүрвижээ гэж үзсэн ба “Рашид Ад Дины бүрэн зохиолын гарчиг”-т дурьдсан 4 боть “Судрын чуулган”-ы нуулган”-ы III боть- “Үе залгамжийн чуулган” хэмээгч тэр болох ёстой гэжээ.

4 боть “Судр” боть “Судрын чуулган” гэдэг нь “Монголын түүх”, “Дэлхийн түүх” (“Өлзийт хааны түүх” ч гэх), “Үе эг гэх), “Үе залгамжийн чуулган”, “Газар зүй” гэсэн 4 ботийг багтааж байжээ. Гэхдээ зөвхөн эхний 2 ботьхний 2 боть нь л бүрэн гүйцэд бичигдсэн ба өнөөдөр бидэнд уламжлагдан иржээ.

А.Zeki Velidi Togan-ий саналыг Karl Jahn болон Брегель нар дэмжсэн байна.⁹ А.Zeki Velidi Togan бас эдгээр бас эдүгээ энэ уламжлагдаж ирсэн бичмэл эх нь үсэг бичгийн хэв байдал болон цаасны шинж чанар шинж чанараас нь харахад бараг XV зууны эцэс XVI зууны эхний үесээр дахин хуулбарласан эх бололтой х бололтой гэж зүйлчилсэн байна.

Японы эрдэмтдэд “Таван аймгийн үе залгамж”-ийн агуулгыг нарийвчлан судлаад “Судрын чуулган”-аасуулган”-аас арай хоживтор үеийн мэдээ сэлт байгааг заасан байна. Ялангуяа судлаач Акасака Цунеаки зох Цунеаки зохиолын ерөнхий хэв байдал нь “Судрын чуулган”-тай зэрүүтэйг анхаарч, ондоо, бас илүүдсэн илүүдсэн, давхацсан, буруудсан зэргийн олон тал оршиж байгаа нь өөрийн түүх бичлэгийн ажилдаа онцжилдаа онцын өндөр шаардлагатай ханддаг Рашид Ад Диний үр бүтээл биш, өөр ямар нэгэн туслах ажилуулах ажил эрхэлдэг хүмүүс Рашид Ад Диний урьдчилан бичсэн “Өмнөх үг”-ийг ёсчлон гүйцэтгэх гүйцэтгэх гэж найруулан эмхэлсэн зүйл болно. Анхны зорилго нь “Судрын чуулган”-ы нэг боть болгоход байолгоход байсан боловч Рашид Ад Дин түүнийг нарийвчлан хянах боломж гараагүй, хэсэг зуур орхисон гэж орхисон гэж үзсэн байна.¹⁰

Дурдагдаж бүрдэгдэж байгаа “Өмнөх үг” гэдэг нь “Таван аймгийн үе залгамж”-ийн удиртгал үг болно. Түүнд: үүнд:

“... ча найруу хэмээн чуулга турки ... эл ү мэргэж	“... чадал мөхөс эмч Рашид (<i>Rashod al-Tabob</i>) хэмээгч бээр турк угсаатны түүхийг эхлэн найруулсан бөгөөд дэлхийн бүх аймгийн түүхийг хамарсан түүх шаштирыг бичтүгэй хэмээн зарлиг болгосон ёсоор түүх шаштирын үйлсийг эхэлвэй. Тэгээд “Судруудын чуулган” (<i>Jawmi' al-tawbrokh</i>) хэмээгч бичгийг найруулан бичив. Дараалан тэрээр туркийн эл овог аймгуудын үе хэлхээг тогтоов. Гэвч тэрээр Арабын бусад эл аймгуудын ... эл үеийн залгамж хараахан тодорхой болоогүй байсан түүнийг туурвиж, эл аймгийн мэргэдээр ариулан шүүлгэж түүнийг “Судруудын чуулган”-ы нэг хэсэг болгов” ¹¹
--	---

гэх мэтээр өгэх мэтээр өгүүлсэн байжээ.

8. □□利《波斯、□□利《波斯文献与蒙古史研究》《民族研究□□》1996年第4期。□□利《波斯文蒙古史文献》《中国□□史地研究》1998年第3期。王一丹《波斯拉施特〈史集〉中国史研究》昆明出版社，2006年。

9. Karl Jahn, Stu. Karl Jahn, Study on Supplementary Persian Sources for the Mongol History of Iran, in Aspects of Altaic Civilization, 1962. Ю.Э. Бреге/62. Ю.Э. Брегель, Персидская лимерамура. Био-библиография обзор. Москва 1972.

10. 赤坂恒明 O. 赤坂恒明『「五族□」と「史集」編纂』『史観』第130冊，1994。

11. 本田実信 『1. 本田実信『モンゴル時代史研究』東京大学出版社，1991.p.30；赤坂恒明『「五族□」と「史集」編纂』『史観』第130'史観』第130冊，1994,pp.52-53。

Цэнгэл

A.Zeki Velidi Togan “Таван аймгийн үе залгамж”-г “Судрын чуулган”-ы бүрэлдэхүүн мөн гэж үзсэн нь даруй энэ “Өмнөх үг”-т тулгуурласан ажээ. Энд Рашид Ад Дин хөнгөвчилсэн хэлбэрээр өөрийн нэрээ дурдсан ба түүний эрхлэн туурвисан алдарт бүтээл “Судрын чуулган” (*Jemi' al-Tawbrokh*) -г олон тоогоор илтгэсэн болов уу гэмээр “Судруудын чуулган” (*Jawemi' al-tawbrokh*) нэрт бичиг дурдагдаж буй. Гэхдээ японы эрдэмтэд харин үүнд уул бичгийн зохиогчийн тухай тодорхой дурдаагүй, “Судруудын чуулган” хэмээх энэ нэрийдэл нь ч “Судрын чуулган”-ыг заасан эсэх нь мөн сэжигтэй гэж үзсэн байна. Гэхдээ агуулгын хувьд монгол хаад ноёдын үе залгамж болон хятадын эл төрийн хаад ноёдын үе залгамжийн тухай тэмдэглэл нь “Судрын чуулган”-ы Стамбулын бичмэл эх болон Тегераны бичмэл эх дэх хаадын үеийн хэлхээтэй ерөнхийдөө адилхан онцлог шинжтэй бөгөөд ялгаатай тал нь цөөхөн хувийг эзэлж байна. Эдгээр ялгааг нь хожим хойно дахин хуулбарлах үед үүссэн боломжихтэй юм. Тиймээс “Судрын чуулган” дахь үе хэлхээ болон энэхүү “Таван аймгийн үе залгамж” гарал нэгтэй гэдэг нь тодорхой мөртлөө үе хэлхээний уулын эх материал нь аль эрт буй болсон гэж үзэх үндэстэй юм.

Бодвоос Рашид Ад Дин нэвтэрхий түүх “Судрын чуулган”-ыг найруулах эхний шатанд эл улс орны хаад ноёдын үе залгамжийн тухай материалуудыг цуглуулж эмхлэн гаргажээ. Тэр үеэс монгол бичгээр байсан алтан ургийн үе хэлхээний бичиг нь нэгэнтээ перс бичгийн хажуугийн хадвартай болсон байх ёмтой. Рашид Ад Дин уул нь бэлэн болсон үе хэлхээний материалыг “Үе залгамжийн чуулган” хэмээх нэрээр “Судрын чуулган”-ы нэг болт болгохоор төлөвлөж, түүнийг “Судрын чуулган”-ы ерөнхий гарчигт бичиж оруулсан байжээ. Эл улс орны хаад ноёдын үе залгамжийг эмхлэх ажил нь маш урагштай явагдаж, удалгүй бэлэн болсон үед Рашид Ад Дин дээр дурьдсан “Өмнөх үг”-ийг туурвисан байна. Түүнд илэрч байгаа “Судруудын чуулган” гэдэг нь “Судрын чуулган”-ы анхны нэрийдэл байжээ. Аажмаар түүнийг найруулах ажил ахихыг дагалдан “Судрын чуулган” хэмээх авсаархан нэр тогтжээ.

Мөн “Судрын чуулган”-ыг найруулах бодитой явцад хаад ноёдын үе залгамжийг тус бүрийнх нь намтартай нь уялдуулан хэмжээ бүхий бүлэг хэсэгт нь хуваарилан тэмдэглэх арга барил шаардагджээ. Түүний үр дүнд уулын нэг боть болох төлөвлөгөө орхигдож, нэгэнтээ бэлтгэсэн үе залгамжийн эх материал нь хэвээрээ үлджээ. Түүнийг “Судрын чуулган” туурвиснаас төдий л хол зайгүй цаг үед хэн нэг түүхчээр дахин хуулбарлаж, өчүүхэн засалт нэмэлт хийсэн нь даруй манда уламжлагдаж ирсэн “Таван аймгийн үе залгамж” хэмээгч дурсгал болно гэж үзвээс илүү зүй ёсонд нийцэх мэт санагдна.

“Таван аймгийн үе залгамж”-ийн хамгийн үнэ цэнтэй агуулга гэвэл перс монгол хоёр бичгээр алтан ургийн үе хэлхээг тэмдэглэсэн зүйл болно. Монгол бичгийн хэв шинжээс нь ажиглаваас үсгийн үе гишүүний холбоос нь эв хавгүй, зарим перс нэр болон монгол нэр нь буруу зэрэгцүүлсэн гэх мэтийн монгол бичгийн хэр хэмжээгээр барагтайхан, эсвэл чадахгүй хүн дуурайлган хуулсан байдал мэдэгдэж байна. Гэхдээ монгол үсгийн бүтэц нь бүрэн бүтэн байгаа ба зөв бичлэгийн хувьд хэтэрхий их алдаа алга. Тиймээс бидэнд уламжлан ирсэн энэхүү эх бичгийн дурсгал бол анхны эхээрээ бус гэдэг нь илэрхий авч, хуулбарт ашигласан уулын эх материал нь чанарлаг, маш тодорхой, дуурайн хуулбарлахад төдий л алдагдахуйц үгүй, боломж сайтай эх байсан нь мэдэгдэж байгаа ажээ.

Хэдийгээр зарим нэг судлаачид Рашид Ад Диний өөрийнх нь гараар бүтээсэн гэж хэлэхээс татгалзаж байгаа боловч, уул дурсгал бичгийн эх үүсвэр нь Рашид Ад Диний санаачлагатай шууд холбоотой мөртлөө “Судрын чуулган”-ы хэрэглэгдэхүүн материал болсон гэж үзэх нь бүрэн үндэслэлтэй байна. Энэ нь рашид Ад Дин “Судрын чуулган” дахь монголын түүхийг


Цэнгэл


туурвихдаа “Алтан дэвтэр” зэрэг язгуурын уйгаржин монгол бичигт түшиглэсэн гэж тэмдэглэсэнтэй аяндаа холбогдох болно. Тиймээс эртний түүх бичгийн судраас хуулбарлагдан үлдсэн энэхүү “Таван аймгийн үе залгамж” нь монголын түүх соёлын судалгааны маш ховор чухаг дурсгал бичиг мөн гэдгийг өгүүлэхийн хэрэг юу билээ.

II. Хэв хэлбэр

Уул дурсгал бичигт араб, монгол, израил, франк (Frank христостан), хятад зэрэг 5 улс орны хаад ноёдын үе залгамжийг хэлхээ хүснэгтээр илэрхийлэн тэмдэглэжээ. Бүх зохиол перс хэлээр бичигдсэн бөгөөд нийт 465 нүүртэй, улаан, хар, шар, хөх хэдэн зүйлийн өнгийг хэрэглэж, шугам зураас татах, дөрвөлжин, дугуриг, гурвалжин хүрээ хийх гэх мэтийн хэв хэлбэрээр хүний нэрүүдийг холбож, дурдсан хэдэн улс орны хаад ноёдын үе залгамжийн хэлхээ хүснэгтийг бүтээжээ.

Бидний гол анхаарал тавьж байгаа монголын алтан ургийн үе залгамж нь нийт 107 нүүр, гол агуулга нь монгол, перс хоёр үсгээр бичигджээ. Түүний үндсэн хэв загвар нь доорх мэт байна.





1. “xxx-ийн хөрөг зураг, ургуудын үе хэлхээ” хэмээх гарчиг: (перс бичгээр)
2. “xxx- ургуудтайгаа” хэмээх гарчиг: (монгол бичгээр)
3. Хөрөг зургийн орон зай. (хоосон)
4. “Түүний үеийн түшмэл” (“амирууд”) хэмээх гарчиг (персээр)
5. Түшмэдүүд (амируудын нэрсийн жагсаалт) (персээр)
6. “Түүний гол хатад” хэмээх гарчиг (персээр)
7. Гол хатдын нэрсийн жагсаалт (персээр)
8. Түүний бага хатад (персээр)
9. Бага хатдын нэрсийн жагсаалт (персээр)
10. Хаадын үе залгамжийн хэлхээс (монгол. персээр)

III. Агуулга

Алтан ургийн үе хэлхээний хэсгийг агуулгаар нь хуваарилж үзвээс доорх гурван зүйл байна.

1. Хаадын ургуудын үеийн хэлхээ. (хэв хэлбэрийн 10)
2. Түшмэл, түшмэдийн (амируудын) бүртгэл хүснэгт. (хэв хэлбэрийн 5)
3. Их бага хатдын бүртгэл хүснэгт. (хэв хэлбэрийн 7, 9)

Алтан ургийн үе хэлхээ нь Добун баянаас хойш Ил хаанд улсын Газан хаан (1295 ~ 1304) хүртэлх нийт 26 хаад ноёдын үе хэлхээг хамарсан нь дараах жагсаалт мэт буй. Сонирхолтой

Цэнгэл

нь Их монгол хаанд улсын хаадаас Гүюг хаан (1206-1248) -ыг л орхигдуулсан байна. Энэ нь “Судрын чуулган”-д ач Ширмүнийг ор эзлүүлэх гэсэн Өгэдэй хааны гэрээс зарлигийг эвдэж, Гүюгээр хаан ширээнд суусан хэмээн зэмлэнгүй хандан бичигдэж байдагтай холбоотой байж таарна. Чингисийн дээдсийн дотроос Байшинхорын хувьд зөвхөн персээр “Байшинхор, хатдын хөрөг зураг, ургуудийн үе хэлхээ” гэж тэмдэглээд, үе залгамжийг эс тэмдэглэсэн нь ч “Судрын чуулган”-ы хэлбэртэй адилхан байна.

1. “Добун буян (баян) ургууд луга бан(-тайгаа)”
2. Алан гуа нарны гил даца(-ээр) төрсөн ургууд луга бан”
3. “Годончор ургууд луга бан”
4. “Гуха ургууд луга бан”
5. “Юдун мэнэн ургууд луга бан”
6. “Хайду хан ургууд луга бан”
7. “Байшинхор, хатдын хөрөг зураг, ургуудын үе хэлхээ” (дутуу)
8. “Тумбинай хан ургууд луга бан”
9. “Абул хан ургууд луга бан”
10. “Бартан баатар ургууд луга бан”
11. “Бүхэй баатар ургууд луга бан”
12. “Чингис хаан ургууд луга бан” (1162-1227)
13. “Зүчи хаан ургууд луга бан” (1177-1225)
14. “Гагаадай ургууд луга бан” (?-1241)
15. “Өгэдэй хаан ургууд луга бан” (1186-1241)
16. “Тлуй хаан ургууд луга бан” (1193-1232)
17. “Нөнх хаан ургууд луга бан” (1208-1259)
18. “Хубилай хаан ургууд луга бан” (1215-1294)
19. “Тэмөр хаан ургууд луга бан” (1265-1307)
20. “Аригбөх ургууд луга бан” (?-1266)
21. “Үлүг хаан ургууд луга бан” (1256-1265)
22. “Аваг хаан ургууд луга бан” (1265-1282)
23. “Ахмад хаан ургууд луга бан” (1282-1284)
24. “Аргун хаан ургууд луга бан” (1284-1291)
25. “Унагт хаан ургууд луга бан” (1291-1295)
26. “Газан хаан ургууд луга бан” (1295-1304)

“Таван аймгийн үе залгамж” бол уйгуржин монгол бичгийн нандин дурсгал билээ. Монгол Перс хоёр хэлээр зэрэгцүүлсэн, нийт 1000 шахам хүний нэр тэмдэглэгдсэн бөгөөд, олонх хүний нэрийн уйгуржин бичлэгийг эндээс анх олж харна. Үе хэлхээн дэх хүний нэрийг тэмдэглэхдээ эрэгтэй хүний нэрийг дөрвөлжинд, эмэгтэй хүний нэрийг дугаригт бичжээ. Бас дээр өгүүлсэн мэтээр хөсөгт доторх гарчгууд монгол бичгээр байхаас гадна зарим нэг овог аймгийн үүсэл гарлын өгөг дээдсийг монгол перс хоёр бичгээр “Ноёкиг, Ургууд Мангадын эцэг”(noyakin uruud mngud-un ečige), “Барласын эцэг”(barlas-un ečige), “Адаргэний эцэг”(adargin--u ečige), “Будаадын эцэг”(budayad-un ečige), “Туладын эцэг”(tulad-un ečige), “Духадын эцэг”(duqad-un ečige) гэхмэтээр тодорхойлон бичжээ.

Бас зарим нэг хэлхээ зураас нь хэд хэдэн хуудсыг алгасан хойшоогоо сунасан үед бас “Үлүг хааны ург нь”(ylekь qan-u uruь инь), “Хубилай хааны ураг нь”(qubilai han-u uruь инь), “Газан хааны ург нь”(Qasan qan-u uruь инь)гэх мэтээр тэр шугамыг чухал зааж илэрхийлсэн байна.

Цэнгэл

Тэдгээрээс үлдэж ирсэн нь ч өдий төдий буй. Жишээ нь: “Судрын чуулган”(“*Jemi' al-Tawbrokh*”)-ы эл эхүүдэд харилцан жаахан зөрүүтэй үе залгамжын хэлхээ хүснэгүүдтэй бөгөөд зарим нэг эхэд цөөхөн ч гэсэн мөн уйгуржин монгол, перс хоёр бичгээр тэмдэглэсэн тохиолдол буй. “Байшинхор хөргүүд” (“*Baysungur Album*”) хэмээгч нь монгол, перс хоёр үсэг зэрэгцүүлсэн, өнгөт сайхан хөрөг зураг хавсаргасан байдаг ба “Язгууртны үе залгамж”, (“*Mu'izz al-Anseb*”) хэмээгч нь “Таван аймгийн үе залгамж”-тай нэлээд адилаатар, мөн өнгөт хөрөг зураг хавсаргасан хэлбэртэй, монгол хаадын үе хэлхээний дурсгал бичгүүд мөн. Бас бид ойлгож мэддэг “Судрын чуулган”, “Дэлхийг дайлан эзэлсний түүх” (“*Terokh-i Jahan-gusha*”)-аас гадна “Өлзийтийн түүх” (“*Terokh-i Üljeitü*”), “ясапын түүх” (“*Terokh-i Vassef*”) гэх мэт монголын эртний түүхтэй холбогдох перс хэлний сурвалж бичгүүд нь харь гүрний судалгаанд идэвхитэй ашиглагдсаар иржээ.

ЗҮҮЛТ ТАЙЛБАР

1. 遠峯四郎:《小林学士将来東洋学書目録(一)-波斯文古抄本撮影目録》《東洋学報》32,1,1948.
2. A.Zeki Velidi Togan, The Composition of the history of the Mongols by Rashī Al-Dīn, Central Asiatic Journal, vol. VII, Nr. 1, 1962, 3.
3. 杉山正明「五族譜簡介」1988年11月13日, 日本史学会。
4. 志茂碩敏「ベルシア語古写本史料精査によるモンゴル帝国の諸王家に関する総合的研究」1997.
5. 本田実信「チンギス ハンの千戸—「元朝秘史」とラシード「集史」との比較を通じて—」『史学雑誌』第62巻第8号、1954. 志茂 敏「ベルシア語文化圏の成立と展開に関する総合的研究」1988. 本田実信「モンゴル時代史研究」東京大学出版社、1991. 杉山正明「ハ不沙大王の令旨碑より」『東洋史研究』52:3, 1993. 松田孝一「オゴデイ諸子ウルスの系譜と継承—ベルシア語写本史料精査によるモンゴル帝国の諸王家に関する総合的研究」(研究代表者志茂碩敏) 1996. 村岡倫「オゴデイ=ウルスの分立」『東洋史苑』39, 1992. 杉山正明「モンゴル帝国と大元ウルス」京都大学学術出版会、2004. 岩武昭男「ラシード著作全集の編纂—〈ワッサーフ史〉著者自筆写本の記述より—」『東洋学報』第78巻第4号 1994. 赤坂恒明「ジュチ裔諸政権史の研究」東京、風間書房、2005. 赤坂恒明「「五族」と「史集」編纂」『史観』第130冊、1994. 赤坂恒明「「五族」モンゴル分支と「史集」の関係」『早稲田大学大学院文学研究科紀要』第41輯第4分冊、1994. 赤坂恒明「「五族」モンゴル分支と「史集」写本」『アジア アフリカ言語文化研究』1998, 55.
6. 《中国百科全 中国史 元史》中国大百科全 出版社、1985年。
7. 利《波斯文文献与蒙古史研究》《民族研究》1996年第4期。 利《波斯文蒙古史文献》《中国 疆史地研究》1998年第3期。 王一丹《波斯拉施特〈史集 中国史〉研究与文本翻》昆 出版社、2006年。
8. Karl Jahn, Study on Supplementary Persian Sources for the Mongol History of Iran, in Aspects of Altaic Civilization, 1962. Ю.Э.Брегель, Персидская лимерамура. Био-библиография обзор, Москва 1972.
9. 赤坂恒明「「五族」と「史集」編纂」『史観』第130冊、1994.
10. 本田実信「モンゴル時代史研究」東京大学出版社、1991. p. 30; 赤坂恒明「「五族」と「史集」編纂」『史観』第130冊、1994. pp. 52-53.

Цэнгэл

ЗУРАГ


1. Өгэдэй болон хатны хөрөг зураг. “Судрын чуулган”
2. Алун гоо нарны хилээр төрсөн ургуудтайгаа “Байшинхор хөргүүд”
3. “Байшинхорын хөргүүд дэх үе хэлхээ”
4. Добун баян ургуудтайгаа “Таван аймгийн үе залгамж”
5. Алун гоо нарны хилээр төрсөн ургуудтайгаа “Таван аймгийн үе залгамж”
6. Зүчи хаан ургуудтайгаа “Таван аймгийн үе залгамж”



1




2




3


Цэнгэл




4



5



6



2